



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот


### Аудитын сэдэв батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.9.7 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан аудитыг хугацаанд нь гүйцэтгэж, аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод хүргүүлж, ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор (Д.Загджав)-т үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны  
2024 оны 05 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДЭВ

| №                                          | Аудитын сэдэв                                                                                                     | Хамрах хүрээ                               | Аудит хийх<br>хугацаа | Аудитын тайлан<br>дүгнэлтийг<br>хүргүүлэх |
|--------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|-----------------------|-------------------------------------------|
| Нэг. Хуулийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв |                                                                                                                   |                                            |                       |                                           |
| 1                                          | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл | Монгол Улсын Засгийн газар,<br>Сангийн яам | 2025.04.14-06.10      | Улсын Их Хурал                            |
| 2                                          | Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх                                                              | Сангийн яам                                | 2025.04.17-05.05      | Төсвийн ерөнхийлөн<br>захирагч            |
| 3                                          | Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх                                            | Төсвийн ерөнхийлөн<br>захирагчид           | 2025.03.24-04.25      | Төсвийн ерөнхийлөн<br>захирагч            |
| 4                                          | Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх                                           | Төсвийн төвлөрүүлэн<br>захирагчид          | 2025.02.27-03.25      | Төсвийн төвлөрүүлэн<br>захирагч           |
| 5                                          | Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх                                                       | Засгийн газрын тусгай<br>сангууд           | 2025.01.02-02.25      | Төсвийн ерөнхийлөн<br>захирагч            |
| 6                                          | Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх                                    | Холбогдох аж ахуйн<br>нэгжүүд              | 2025.02.15-03.15      | Төсвийн ерөнхийлөн<br>захирагч            |
| 7                                          | Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх                                                               | Төсөл, хөтөлбөрүүд                         | 2025.01.02-02.25      | Төсвийн ерөнхийлөн<br>захирагч            |
| 8                                          | Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх                                                            | Төсвийн шууд<br>захирагчид                 | 2025.01.02-02.25      | Төсвийн шууд<br>захирагч                  |

|    |                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                      |                  |                                                |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|------------------|------------------------------------------------|
| 9  | Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх   | Монгол Улсын Засгийн газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, бусад холбогдох байгууллага              | 2025.01.16-12.15 | Төсвийн ерөнхийлөн захирагч                    |
| 10 | Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, бусад холбогдох байгууллага | 2025.01.16-12.15 | Төсвийн ерөнхийлөн захирагч                    |
| 11 | Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх                                                                                                                                                                                                        | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам                                                              | 2025.08.25-10.15 | Төсвийн байнгын хороо                          |
| 12 | Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт                                                                                                                                                                                        | Бүх шатны төсвийн захирагч                                                                           | 2025.01.02-06.10 | Төсвийн байнгын хороо, холбогдох байгууллагууд |
| 13 | Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт                                                                                                                                                                        | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, бусад холбогдох байгууллага      | 2025.01.03-04.01 | Төсвийн байнгын хороо, холбогдох байгууллагууд |
| 14 | Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт                                                                                                                                                                             | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам бусад холбогдох байгууллага                    | 2025.01.02-03.15 | Улсын Их Хурал                                 |
| 15 | Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл                                                                                                                                                                                                   | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, бусад холбогдох байгууллага                   | 2025.01.02-03.15 | Улсын Их Хурал                                 |

|                                                |                                                                                                                                                   |                                                                                                     |                  |                                                                                                  |
|------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
| 16                                             | Дипломат төлөөлөгчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл                                                                        | Дипломат төлөөлөгчийн газрууд                                                                       | 2025.07.15-11.10 | Төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох байгууллагууд                                             |
| 17                                             | Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалт                                                                                              | Холбогдох байгууллага                                                                               | 2025.02.10-07.01 | Тусгай хяналтын дэд хороо, холбогдох байгууллагууд                                               |
| <b>Хоёр. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв</b> |                                                                                                                                                   |                                                                                                     |                  |                                                                                                  |
| 1                                              | Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүн                                                                                          | Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, бусад холбогдох байгууллага | 2025.04.07-11.15 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо                                                |
| 2                                              | Гамшгийн бэлэн байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт                                                                            | Монгол Улсын Засгийн газар, бусад холбогдох байгууллага                                             | 2025.04.01-12.15 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо                                                    |
| 3                                              | Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн                                                                   | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, бусад холбогдох байгууллага     | 2025.04.06-07.10 | Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хороо                                         |
| 4                                              | Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /"Тогтвортой хөгжлийн зорилт-2030"-ын 6.1/ | Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, холбогдох байгууллага     | 2025.08.15-12.17 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 5                                              | Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн                            | Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, бусад байгууллага         | 2025.08.15-12.15 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо                                                |

|    |                                                                                                                                                |                                                                                                     |                  |                                                              |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------------------------------------------------------------|
| 6  | Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө                                                                          | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, холбогдох байгууллага | 2025.04.04-07.10 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо            |
| 7  | Төрөөс аялал, жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт                                                         | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, бусад холбогдох байгууллага                           | 2025.08.15-12.15 | Эдийн засгийн байнгын хороо                                  |
| 8  | Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн                                                | Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, холбогдох байгууллага                          | 2025.04.07-12.10 | Төсвийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо |
| 9  | Уул уурхайн тусгай зөвшөөрөл олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт                                                                               | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, бусад холбогдох байгууллага                                         | 2025.04.16-07.09 | Эдийн засгийн байнгын хороо                                  |
| 10 | Монгол-Оросын хамтарсан “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөө, үр ашиг | Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, бусад холбогдох байгууллага                 | 2025.01.13-06.30 | Эдийн засгийн байнгын хороо                                  |
| 11 | “Оюу толгой” ХХК-ийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн                                                                                     | Монгол Улсын Засгийн газар, “Эрдэс Монгол” ХК                                                       | 2025.01.01-12.25 | Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо           |
| 12 | Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн                                                                    | Боловсролын яам, холбогдох байгууллага                                                              | 2025.06.01-09.01 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо        |
| 13 | Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө                                                                               | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                                                           | 2025.09.15-12.25 | Эдийн засгийн байнгын хороо,                                 |

|    |                                                                                                                                                                     |                                                                                                     |                                   |                                                                          |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|--------------------------------------------------------------------------|
|    |                                                                                                                                                                     |                                                                                                     |                                   | Төсвийн байнгын хороо                                                    |
| 14 | Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүн                                                                                               | Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам                              | 2025.09.01-11.15                  | Нийгмийн бодлогын байнгын хороо                                          |
| 15 | Стратегийн ач холбогдол бүхий төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл                                                                     | Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                               | 2025.08.15-12.01                  | Эдийн засгийн байнгын хороо                                              |
| 16 | Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө                                   | Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                               | 2025.08.15-11.15                  | Эдийн засгийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо    |
| 17 | Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах.                      | Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, холбогдох байгууллага                          | 2025.08.15-11.15                  | Төсвийн байнгын хороо                                                    |
| 18 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн                                                                                                                   | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллага                                | 2025.01.15-06.20<br>1, 2-р улирал | Төсвийн байнгын хороо                                                    |
| 19 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө аж ахуйн карпорац” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүн | Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, холбогдох бусад байгууллага | 2025.08.15-12.15<br>3, 4-р улирал | Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |

|    |                                                                                                                                        |                                                                            |                       |                                                                       |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------------------------------------------------------|
| 20 | Арилжааны банкуудад төсөв, Засгийн газрын тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс байршуулсан хөрөнгийн үр дүн | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллага       | 2025.12.15-2026.06.10 | Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо                    |
| 21 | Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг, зардал                                              | Монгол Улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, холбогдох бусад байгууллага  | 2025.01.15-06.20      | Эдийн засгийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо |
| 22 | Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрөөс баримталж буй бодлого болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн                     | Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам, холбогдох бусад байгууллага | 2025.08.15-2025.12.15 | Нийгмийн бодлогын байнгын хороо                                       |
| 23 | Үнэ тогтворжуулах зорилгоор төрөөс олгож буй татаас, нөхөн олговрын зарцуулалтын үр дүн                                                | Монгол Улсын Засгийн газар, холбогдох бусад байгууллага                    | 2025.12.15-2026.06.10 | Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо                    |
| 24 | Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт                                                                                         | Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллага       | 2025.05.01-2025.09.30 | Төсвийн байнгын хороо                                                 |